



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит 11 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 11 дүгээр хуралдаан 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар Тариф шинэчлэн батлах тухай (Монгол шуудан ХК); Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2023 оны эхний хагас жилийн үндсэн үзүүлэлтийн тайлангийн танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, түдгэлзүүлэх тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, Дугаар ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт); Бусад: Хорооны дарга, гишүүдэд ОНДО ХХК-иас ирүүлсэн албан тоот, гомдлын талаар танилцуулга зэрэг асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 7 тогтоолыг батлан шийдвэрлэв.

Монгол шуудан ХК нь Хот хоорондын үндсэн шуудангийн үйлчилгээний зах зээл /ШӨХТГ-ын 2012 оны 06 тоот тогтоол/, Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний зах зээл /ШӨХТГ-ын 2015 оны 17 тоот тогтоол/, Улс хоорондын энгийн шуудангийн үйлчилгээний зах зээл /ШӨХТГ-ын 2017 оны 15 тоот тогтоол/, Улс хоорондын буухиа шуудангийн үйлчилгээний зах зээл /ШӨХТГ-ын 2017 оны 11 тоот тогтоол/, давамгайл байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдсон байна. Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.5 болон Шуудангийн тухай хуулийн 18.1, 18.2-д заасны дагуу шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч Монгол шуудан ХК-ийн үндсэн шуудангийн үйлчилгээний үнэ тарифыг хянан тогтоож, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 51 тоот тогтоолоор баталснаар мөрдөн ажиллаж байна. Эдгээр тогтоосон тарифыг шинэчлэх талаар Монгол шуудан ХК-иас удаа даруу ирүүлсэн хүсэлт санал, үндэслэл тооцоо судалгаа болон Хорооны хууль, тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд судалгаа тооцоолол, үндэслэлийг хянаж үзээд, тус хорооны Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газар, Шуудангийн зохицуулалтын газар хамтран шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний зах зээл, Улс хоорондын шуудангийн үйлчилгээний зах зээл /Энгийн/, Улс хоорондын шуудангийн үйлчилгээний зах зээл /Буухиа/, Хот хоорондын шуудангийн үйлчилгээний зах зээлүүдэд давамгайл байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдсон Монгол шуудан ХК-ийн нэр бүхий үйлчилгээний тарифыг шинэчлэх асуудлыг боловсруулжээ. Түүнчлэн дээрх нэр бүхий тарифыг шинэчлэх асуудлыг боловсруулахдаа дотоод бичиг захидал-бүтээгдэхүүн үйлчилгээний бодит өртөгт суурилан үнэ тарифыг нэмэгдүүлж, алдагдлыг бууруулах; дотоод илгээлт-зах зээлийн хэрэгцээ шаардлага, өрсөлдөөний нөхцөл байдалд тулгуурлан тарифын уян хатан байдлыг бий болгож бодит өсөлтийг хангах; гадаад бичиг захидал-бүтээгдэхүүн үйлчилгээний бодит өртөгт суурилсан үнэ тарифыг боловсруулан мөрдөж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх; гадаад бүртгэлийн хураамж-Дэлхийн шуудан холбооны байгууллагаас зарласан ханшийн дагуу өртгийг тодорхойлон нэмэгдүүлэх гол өөрчлөлт; макро орчны нөлөөгөөр бүтээгдэхүүн үйлчилгээний бодит өртөгт үзүүлсэн нөлөөллийг бууруулах зэрэг асуудлыг харгалзан үзсэн байна.

Хорооны 2023 оны ээлжит 11 дүгээр хуралдаанд холбогдох ажлын албанаас “Тариф шинэчлэн батлах тухай” танилцуулга, тогтоол шийдвэрийн төсөл, хавсралт баримт бичиг болох “Монгол шуудан ХК-ийн нэр бүхий үйлчилгээний тарифын хэмжээ”-ний төсөл, ирүүлсэн саналын товчооны нэгтгэл, уулзалт хэлэлцүүлгийн үр дүн зэрэг баримт бичгийг хэлэлцээд, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 98 тоот “Тариф шинэчлэн батлах тухай” тогтоолыг хавсралтын хамт баталсан. Тогтоолд, Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний зах зээл, Улс хоорондын шуудангийн үйлчилгээний зах зээл /Энгийн/, Улс хоорондын шуудангийн үйлчилгээний зах зээл /Буухиа/, Хот хоорондын шуудангийн үйлчилгээний зах зээлүүдэд давамгайл байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдсон Монгол шуудан ХК-ийн нэр бүхий үйлчилгээний тарифыг тогтоолын хавсралт ёсоор шинэчлэн баталж, батлагдсан тарифын хязгаарт багтаан үйлчилгээний тарифыг тогтоох, үйлчилж эхлэхээс өмнө хэрэглэгчдэд сурталчлах, бэлтгэл ажлыг зохион байгуулж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллахыг Монгол шуудан ХК-д зөвшөөрөв. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 51 дүгээр тогтоолыг хүчингүй болголоо.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2023 оны эхний хагас жилийн үндсэн үзүүлэлтийн тайлангийн танилцуулгыг сонсож, цаашид тус хорооны газар, хэлтсүүд статистик үзүүлэлтийн тайланд дүн шинжилгээ анализ хийж, зохицуулалтын орчин, цаашдын үйл ажиллагааны хандлагад харгалзан үзэх, тухай бүр санал зөвлөмж боловсруулан танилцуулж ажиллахыг Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газар /Д.Ариунболд/-т үүрэг болгов.

Бусад асуудлын хүрээнд, Хорооны дарга, гишүүдэд ОНДО ХХК-иас ирүүлсэн албан тоот, гомдлын талаар танилцуулга (“5G сүлжээний радио давтамжийн зурвасын хуваарилалт, зохицуулалтын тухай; ХХЗХ-ны 2023 оны 44 тоот тогтоол хүчингүй болгуулах тухай; Хариу хүргүүлэх тухай-Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г шинэчлэх төслийн тухай)-ыг сонсож, холбогдох арга хэмжээ авах, албан тоотоор хариу өгч ажиллахыг ажлын албанд даалгав.

Хорооны 2023 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, түдгэлзүүлэх тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, Дугаар ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) холбогдох газар хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 6 тогтоол, хавсралтын төслийг тус тус авч хэлэлцээд, тус хуралдаанаас 6 тогтоолыг хавсралтын хамт баталсан. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 99 тоот тогтоолын хавсралтаар 8 хуулийн этгээдэд 8 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалтыг тус тус үндэслэн

2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 100 тоот тогтоолоор 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 101 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 3 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 102 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг 45 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 103 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдэд 3 харилцаа холбооны сүлжээний дугаарыг олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 104 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний 3 дугаар ашиглалтын хугацааг сунгаж тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-09-06